

ФИЛОСОФИЙН ТҮҮХ СУДЛАЛЫН УЧИР ХОЛБОГДЛЫН ТУХАЙ ГЕГЕЛИЙН БАРИМТЛАЛ

Г.Лодой

МУИС, Нийгмийн шинжлэх ухааны сургууль

Түлхүүр үгс: Философи, философийн түүх, түүхэн ба логик үйл явц, залгамж чанар, онол ба түүхийн нэгдэл.

Философийн аливаа асуудлыг дэвшүүлэх, тайлбарлахад философийн түүх ямар нэгэн ач холбогдолтой юу? гэдэг асуултанд зарим философичид сөрөг хариулт өгөх явдал байдаг. Тэдний бодлоор философийн сургаал бүхэн өөрийгөө зөвтгөж байдаг тул философийн түүх бол бүхэлдээ төөрөгдлийн түүх байдаг ажээ. Өнгөрсөн үеийн үзэл санаа нь хоцрогдмол зүйл байдаг тул өнөө үед учир холбогдолгүй, үнэ цэнэгүй болсон мэтээр үздэг хүмүүс буй.

Философи сэтгэлгээний өнгөрсөн болон эдүгээ үеийн харилцан холбооны асуудал нарийн төвөгтэй бөгөөд судлаачийн хувийн үнэлэмж, үзэл санааны чиг баримтлалаас хамаарч янз бүрээр эл асуудалд ханддаг. Ямар нэгэн философийн сургаалыг хэтэрхий туйлшруулж, бишрэн дагалдагсад философийн түүх судлалын учир холбогдлыг дутуу үнэлэх, эсвэл үгүйсгэх хандлагатай үнэлэмжийг баримталдаг тал буй.

Философи болон философийн түүхийн холбоо хамаарлын асуудлыг Гегель ул үндэстэй судлаж, ихээхэн оновчтой, үнэтэй санаа дүгнэлтүүд дэвшүүлсэн байдаг. Философийн сургаалууд нь өөр хоорондоо зарчмын хувьд ялгаатай байдаг тул философийн түүх бол "янз бүрийн санал бодлын тойм", "төөрөгдлийн олонлог" байдаг мэтээр үздэг хүмүүсийг Гегель эрс эсэргүүцэн шүүмжилж байжээ. Тэрбээр бичихдээ "философийн түүхийг янз бүрийн үзэл бодлын тухай өгүүлэмж гэж үзвэл философийн түүх судлал нь зугаа гаргах төдий зүйл, эсвэл бүхнийг мэдэхийг зоригч "эрдэмтэний" сонирхол татах зүйл болно. Бүхнийг мэдэгч "эрдэмтэний" хувьд огт хэрэггүй, учир утгагүй зүйлс хүртэл сонирхолтой байдгийн учир нь тэдгээрийг тэрбээр мэддэгт л оршдог"¹ гэжээ.

¹ Г. В. Гегель. Сочинения. Т. 9. С. 18.

Философийн түүхийг үгүйсгэх үзлийг Гегель эрс няцааж байсан бөгөөд философийн аливаа сургаал бүхэн ердийн нэгэн "бодол, санал" бус, харин жинхэнэ мэдлэг, үнэний илэрхийлэл байдаг гэдгийг нотлохыг тэр бээр хичээсэн нэгэн юм. Философийн сургаал нь ямар нэгэн үнэнийг илэрхийлж байдаг тул философи сэтгэлгээг өрнүүлэх мөнхийн эх сурвалжууд болж байх ёстой ажээ.

Философийн сургаал бүхэн өөрийн онцлогтой, бусдаасаа ялгаатай байдгийн учир шалтгааныг Гегель философийн судлагдахууны онцлогтой холбон тайлбарлаж байв. Гегелийн үзлээр, философийн танин мэдэхүйн судлагдахуун нь ялгаатай зүйлсийн нэгдэл буюу тодорхой чанар бүхий зүйл байх ёстой ажээ. Ойлголт санаа бол янз бүрийн тал, шинж, харилцааг нэгдэлд нь илэрхийлдэг тул түүнийг бүхэлд нь цогцоор танин мэдэх үйл явц түүхэн урт цаг хугацаанд хэрэгжих боломжтой юм. Философийн түүхэнд янз бүрийн сургаалууд тодорхой ойлголт-санааны аль нэгэн талыг нь илэрхийлж, нотлох батлах оролдлого хийсээр ирсэн байдаг нь философийн судлагдахууныг алхам алхмаар танин мэдэх зайлшгүй шаардлагатай холбоотой ажээ. Гегелийн үзлээр, өнгөцхөн харахад философийн сургаалууд бие биенээ үгүйсгэж байгаа мэт боловч үнэн хэрэгтээ энэ бол зөвхөн үзэгдэх байдал төдий зүйл юм.² Философийн түүх судлалын гол зорилго нь энэхүү үзэгдэх байдлыг арилгаж түүний цаана орших нэгдмэл, тодорхой ойлголт-санааг олж илэрхийлэх явдал гэж Гегель үзэж байв.

Ялгаатай мэт санагдаж байсан философийн сургаалууд нь нэгэн бүхэл зүйлийн зайлшгүй байх ёстой талуудыг илэрхийлдэг учир "философийн сургаал бүхэн аугаа үнэнийг өөртөө агуулдаг бөгөөд философийн түүх бол утга учиргүй зүйлсийн цуглуулгын үзүүлбэр бус, харин "тэнгэрлэг дүр-бүтээлүүдийн харш"³ ажээ. Иймд философийн сургаал бүхэн үгүйсгэгдэж байгаагүй бөгөөд үгүйсгэж болохгүй⁴ гэж Гегель үзэж байв. Иймд Платон, Аристотель, Декарт, Кант нарын сургаалд буй үнэн санаа мөнхийн шинжтэй

² Г. В. Гегель. Сочинения. Т. 1. С. 31

³ Там же. с. 147.

⁴ Там же. с. 148.

бөгөөд философийн түүх “өнгөрснийг бус эдүгээ хүртэл оршсоор буй мөнхийн зүйлсийг шинжилдэг”⁵ ажээ.

“Философийн сургаал бүхэн зайлшгүй гарч ирсэн бөгөөд эдүгээ ч оршсоор буй нь зайлшгүй. Философийн нэг ч сургаал үгүй болоогүй бөгөөд нэг бүхэл зүйлийн янз бүрийн талууд болж философид бүгдээрээ хадгалагдан үлдсэн юм. Философийн зарчмууд хадгалагдан үлддэг тул шинэхэн философи гэдэг бол өмнө үеийнхээ философийн бүх зарчмуудын үр дүн байдаг. Иймд философийн нэг ч систем няцаагдаагүй болно⁶ гэж Гегель бичсэн буй. Энэ санаа нь “сургаал гэж нэрлэгдсэн бүхэнд сургамжтай зүйл ямагт байдаг” гэсэн В.Инжинашийн өгүүлэмжтэй утга нэгэн болой.

Философийн сургаал бүхэн бүхэлдээ туйлын үнэн байсан гэж Гегель үзээгүй юм. Түүний үзлээр, философийн сургаал бүхэн өөрийн зарчимтай байдаг боловч түүнийг дараа үеийн сургаал нь улам тодорхой болгон гүнзгийрүүлж туйлын үнэнд ойртуулсаар ирдэг ажээ.

Философи сэтгэлгээний хөгжлийн түүхийн үйл явцад философич бүхэн нэг л судлагдахууны аль нэгэн талыг нь шинжлэн боловсруулж байсан тул философийн янз бүрийн талыг илэрхийлдэг байна. Энэ тухай Гегель бичихдээ: “Ялгаатай мэт санагдаж буй философийн сургаалууд нь хөгжлийнхөө янз бүрийн шатанд буй нэг л философиийг илэрхийлдэг болохыг философийн түүх харуулдаг”⁷ гэжээ. Философийн түүх судлал гэдэг бол өнгөрч, үгүй болсон зүйлсийг судалдаг бус, эдүгээд өвлөгдөж хадгалагдсаар буй үнэний хувь хэсгүүдийг судалдаг учир философийн түүх судлал бол философиийг өөрийг нь судлана гэсэн үг болно.⁸ Философийн түүх судлалын учир холбогдол нь философийн асуудлуудыг дэвшүүлж, шийдвэрлэж, тайлбарлаж ирсэн түүхийн үнэн хийгээд төөрөгдлийг ухаарч ойлгох үндсэн дээр эдүгээ үеийн философи сэтгэлгээг хөгжүүлэхэд оршдог.

Философийн шинэ сургаал нь өмнөх үеийнхээ философийн үнэн зөв зарчмуудыг өөртөө шингээн өвлөж шинэ зарчмын үндэслэлд тулгуурлан синтезлэх ёстой гэж Гегель үзэж байв. Ийм учраас тэрбээр “Логикийн ухаан”

⁵ Г. В. Гегель. Сочинения. Т. 1. С. 147.

⁶ Г. В. Гегель. Сочинения. Т. 9. С. 40.

⁷ Г. В. Гегель. Сочинения. Т. 1. С. 31.

⁸ Г. В. Гегель. Сочинения. Т. 9. С. 35.

зохиолдоо философийн категориудыг авч үзэхдээ ойлголтуудын дарааллыг нь тэдгээрийн философи сэтгэлгээний түүхэнд боловсруулж ирсэн дараалалтай харгалзуулсан байдаг. Логикийн эхлэл нь философийн түүхийн эхлэлтэй давхцах ёстой ажээ. Энэ тухай Гегель бичихдээ: "Шинжлэх ухаанд эхний алхам болж буй зүйл түүхийн хувьд мөн анхных байх ёстой"⁹ гэсэн буй. Философийн шинэ сургаал нь "философийн бүх түүхийг тусгасан толь"¹⁰ байх ёстой ажээ.

Философийн ойлголтуудын утга санааг тодорхойлохын тулд философийн түүхэнд тэдгээрийг тайлбарлаж байсан өнгөц хэлбэр, хэрэглэж байсан аргаас нь ангижруулж цэвэр санааг нь авбал философийн санааг логик тодорхойлолтонд оруулж болно гэж Гегель үзэж байжээ. Ийм учраас Гегелийн диалектикийн үндсэн зарчмын нэг бол түүхэн ба логик үйл явцын давхцалын зарчим гэж үздэг. Ойлголтуудын логик дарааллын диалектик холбоо нь түүхэн дарааллаа илэрхийлэх ёстой гэдэг зарчмыг Гегель "Логикийн ухаан" зохиолдоо баримтлал болгосон байдаг.

Философийн сургаалаа боловсруулахдаа Гегель өмнөх үеийн философийн бүх түүхийг хураангуйлсан шинэ "Логикийг" бүтээх зорилт тавьсан бөгөөд энэ зорилтоо зохих хэмжээнд хэрэгжүүлж чадсан юм. Гэвч өөрийн дэвшүүлсэн диалектик аргын зарчмуудаа хэтэрхий туйлчилж туйлын загвар болгосон нь зарим талаар алдаанд хүргэж, зохиомол шинжтэй үндэслэлүүд гаргахад хүргэснийг анхаарууштай.

Түүх судлалгүйгээр шинжлэх ухаанд ямар нэгэн шинэ онол сургаал гаргах боломжгүй гэсэн Гегелийн баримтлал эдүгээ үнэ цэнэтэй хэвээрээ байгаа бөгөөд оюун санаа өөрийгөө ойлголтын төвшинд ухаарах үйл ажиллагааны нэг хэлбэр болох философи сэтгэлгээний хөгжил, философийн түүхээс ангид гадуур явагдах боломжгүй гэдэг нь хэн бүхэнд ойлгомжтой билээ. "Түүхгүй онол доголлон, онолгүй түүх харалган" гэдэг өгүүлэмжийн утга санааг тайлахад Гегелийн сургаал ихээхэн ач холбогдолтой болохыг үгүйсгэх аргагүй юм.

⁹ Г. В. Гегель. Сочинения. Т. 1. С. 147.

¹⁰ Г. В. Гегель. Сочинения. Т. 9. С. 44.